



МОНГОЛ УЛСЫН  
КОНСЕРВАТОРИ

**Монгол Улсын Консерваторийн**

**2020-2021 хичээлийн жилийн элсэлтийн шалгалтын мэдээлэл**

- ❖ КОВИД-19 тархалтын халдвар, хамгаалалтын онцгой нөхцлийн үед болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, УОК-ын заавар зөвлөмжийн дагуу элсэлтийн шалгалтыг хариуцлагын өндөр түвшинд зохион байгуулах ба бүртгэлийг цахим хэлбэрээр явуулна.
- ❖ Элсэлтийн шалгалтын цахим бүртгэл нь Монгол Улсын Консерваторийн вебсайт ([www.conservatory.edu.mn](http://www.conservatory.edu.mn)) болон тус сургуулийн албан ёсны FaceBook пейж хуудсаар (<https://www.facebook.com/mglconservatory/>) **2020 оны 8 сарын 17-ны өдрөөс 8-р сарын 21-ны өдрийг дуустал өдөр бүр 09.00-17.00 цагийн хооронд хийгдэнэ.**
- ❖ Цахим бүртгэлд хамрагдсан хүүхдүүдийг **8 сарын 24-ны өдрөөс** гурван шат бүхий элсэлтийн шалгалтад оруулна. Шалгалтад орох өдөр, цагийг бүртгэлийн дарааллын дагуу гар утасны мессеж болон Консерваторийн вебсайт, пейж хуудсаар мэдээлнэ.
- ❖ Шалгалтад орох элсэгчийг хариуцаж нэг л хүн ирэх ба Консерваторийн хичээлийн байранд бүлэг бөөгнөрөл үүсгэхгүй байхыг анхааруулж байна.
- ❖ Элсэхийг хүсэгч нь өөрийн хүсэлтээр 2 мэргэжил сонгон бүртгүүлж болно.
- ❖ Шалгалтад ирэхдээ төрсний гэрчилгээг эх хувиар авчирна. Шалгалтын хураамжийг шалгалтад орох өдрөө бэлнээр төлж, шалгалтын хуудас авна.
- ❖ Шалгалтад ирэхдээ амны хаалттай байх ба халдвар хамгааллын дэглэмийг бүрэн сахина.
- ❖ Консерваторийн сонгодог хөгжмийн мэргэжлийн сургуулийн 1-р ангид элсэхийг хүсэгч 6 настай хүүхдүүд өөрийн харьяаллын хот, дүүргийн сургуульдаа заавал бүртгүүлсэн байх шаардлагатайг анхаарна уу?